

ДОРНОД АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭМЖИЙН БАЙЦААГЧ
Ч.БЯМБАХИШИГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт					Гүйцэтгэлийн түвшин	
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Хүрсэн түвшин (биелэлт)	Эх д. х
			1	2		
Нэг. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгох						
1.1	Нийгмийн даатгалын багц хуулийн талаар иргэд, даатгуулагчдад сурталчлах	Ажил олгогч, даатгуулагчдад зөвлөгөө, мэдээлэл тогтмол өгч ажиллах. • Цахимаар • Биеэр	• Цахимаар 20-30 • Биеэр ирсэн тухай бүрд	• Цахимаар 25-35 • Биеэр ирсэн тухай бүрд	Нийгмийн даатгалын багц хуулийг иргэд, даатгуулагч, ажил олгогчдад сурталчилах ажлын хүрээнд хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны тэтгэмжийн хүсэлт илгээх талаар болон Portal.ndaigal.mn сайтаар хүсэлт илгээсэн аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогч болон сайн дурын даатгуулагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, даатгалын сангаас олгох тэтгэмжийн тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийн талаар зөвлөгөө мэдээллийг нийт давхардсан тоогоор 2992 иргэнд хүргэж ажилласан.	21
1.1.1	Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны	ХЧТА-ны болон жирэмсний амаржсаны тэтгэмж	ХЧТА 414,653,142.00 /мян. Төг/	ХЧТА 414,653,142.00 /мян. Төг/	Тайлант хугацаанд хугацаанд тэтгэмжийн даатгалын сангаас 2570 даатгуулагчийн 518,0 сая төгрөгийн	21

	Болон жирэмсэн амаржсаны тэтгэмж тогтоох, олгох	авах даатгуулагчдын цахимаар ирүүлсэн тэтгэмжийн хүсэлтийг нягтлан шалгаж, тогтоон дотоод хяналтаар оруулж хянуулах	ЖА 3,602,296.14 /мян. Төг/	ЖА 3,602,296.14 /мян. Төг/	хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгогдсон нь өнгөрсөн оны мөн үеэс 314 даатгуулагчаар даатгуулагчийн тоо нэмэгдсэн ба зардал 97.3 мянган төгрөг буюу 23,1 хувиар өссөн, 1332 даатгуулагчийн 3,9 тэрбум төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмжийг шалгаж, дотоод хяналтаар хянуулж, гүйлгээ хийхэд бэлтгэн жагсаалт үйлдэн сангийн нягтлан бодогчид хүлээлгэн өгч ажиллалаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 12 даатгуулагчаар даатгуулагчийн тоо багассан боловч зардал 1296080,0 мянган төгрөг буюу 49,5 хувиар өссөн нь хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого нэмэгдсэнтэй холбоотой гэж дүгнэж байна.		
1.1.2	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэмж тогтоох олгох	Ажил олгогчоос ирсэн ҮОМШӨ-ний тэтгэмжийн тооцоот хийж мэдээлэлд оруулан дотоод хяналтаар хянуулж нягтлан бодогчид хүлээлгэн өгч ажиллах	ҮОМШӨ 45,007,127.00	ҮОМШӨ 45,007,127.00	2024 онд тус сангаас 18 даатгуулагчийн 78,9 сая төгрөгийн ХЧТА-ны тэтгэмжийн бодолт тооцооллыг шалгаж, дотоод хяналтаар хянуулж, гүйлгээ хийхэд бэлтгэн жагсаалт үйлдэн сангийн нягтлан бодогчид хүлээлгэн өгч ажиллалаа. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас гарсан зардлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 8 даатгуулагчаар хөдөлмөрийн чадвар түр алдагчийн тоо буурсан нь НДЕГ-аас жил бүр зохион байгуулдаг ХАБЭА-н сургалт анхан шатны нэгж болох аж ахуйн нэгж байгууллагуудад үр дүнтэй хэрэгжиж байгаа боловч даатгуулагчид олгох зардлын хэмжээ 43,5 сая төгрөгөөр буюу 44,8 хувиар өссөн нь хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого нэмэгдсэнтэй холбоотой гэж дүгнэж байна.	2024.01.01 2024.12.31	100%

					Ажилгүйдлийн даатгалын сангаас тайлант хугацаанд 574 даатгуулагч тэтгэмж авах хүсэлт гаргасан нийт 574 даатгуулагчдын 2,1 тэрбум төгрөгийн зардал гарсан байна. Үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 18 даатгуулагчаар тэтгэмж авах даатгуулагчдын тоо өссөн ба зардал 36,1 орчим хувиар өссөн байна.		
1.1.3	Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж тогтоох, олгох	Ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчдын тэтгэмж тогтооход шаардагдах холбогдох баримтыг хуулинд заасан хугацаанд хүлээн авч, эрх үүсээн даатгуулагчийг хүсэлт гаргасан өдрөөс бүртгэж тэтгэмж тогтоох	Ажилгүйдэл 1,663,467,600.0 0 /мян. төг/	Ажилгүйдэл 1,663,467,600.0 0 /мян. төг/	Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авч буй даатгуулагч тэтгэмжийн хугацаа дуусаагүй байхад ажилд орсноос ажилгүйдлийн даатгалын санд илүү авсан тэтгэмжийг буцаан төлүүлэх ажлыг тогтмол хийж гүйцэтгэж ажиллав. Тайлант хугацаанд тус санд 36 иргэний ажилд орсон тушаалыг авчруулж тооцоо хийн 6 иргэний 2,8 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын санд буцааж төлүүлсэн ба тэтгэмж олгох хугацаа дуусгавар болсон буюу тооцоо дууссан даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэрэгт тэмдэглэл хөтөлж ажиллалаа.	2024.01.01 2024.12.31	100%
1.1.4	Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авах иргэдэд чиглэсэн үйлчилгээ	Төрөөс нийгмийн даатгалын талаар баримталж буй бодлого, шийдвэрийг ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй иргэд даатгуулагчдад хүргэж ажиллах	Жилийн турш	Жилийн турш	Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авах сайн дурын даатгуулагч иргэдэд мэдээллийг тухай бүр өгч ажилласан ба бүрдүүлэх материал, тэтгэмж авах хүсэлт илгээх зааварчилгааг тогтмол өгч ажиллав. Үүнд давхардсан тоогоор хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах сайн дурын даатгуулагч 196 иргэн, жирэмсэн амаржсаны тэтгэмж авах 600 даатгуулагч иргэнд зөвлөгөө өгч ажиллалаа.	2024.01.01 2024.12.31	100%
1.1.5	Эмнэлгийн байгууллагаас илгээсэн ХЧТА-ны болон ЖА-ны тэтгэмжийн хүсэлтийг цахимаар илгээх болон цаасан баримтыг баталгаажуулах	Натглан бодогч нарт зөвлөгөө, мэдээлэл өгөх, заавар журмыг боломжтой	Тогтмол	Тогтмол	ХЧТА-ны тэтгэмжийн эмнэлгийн хуудсыг эмнэлгийн байгууллагаас ажил олгогчид цахимаар илгээснээс хойш натглан бодогч нарын гаргаж	2024.01.01 2024.12.31	100%

	талаар ААНБ-ын холбогдох албан хаагчидтай хамтран ажиллах	хэлбэрээр танилцуулж хүргэж ажиллах			байгаа алдааг, алдаа гаргаснаас үүдэн гарах даатгуулагчийн хохиорол, гарч болох эрсдлийн талаар аймгийн хэмжээний нягтлан бодогч нарын фэйсбүүкийн групп чатаар тухай бүр мэдээлэл өгч ажиллав. -Жирэмсэн амаржсаны тэтгэмж авах даатгуулагч иргэн, сайн дурын даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг эрүүл мэндийн байгууллагаас НДХ-т цахимаар илгээсний дараа даатгуулагч иргэд Portal.ndaatgal.mn сайтад E-mongolia төрийн үйлчилгээний цахим системд нэвтрэх өөрийн эрхээр эсвэл интернет банкны эрхээр нэвтэрч тэтгэмж авах хүсэлтийг илгээх талаарх мэдээллийг өгч ажиллалаа.		
1.1.6	Тэтгэмжийн анхан шатны баримтын бүрдэл буюу цахимаар илгээсэн өргөдөл хүсэлтийг шалгаж нягтлан хүлээж авах	Тэтгэмжийн тооцоог хийж мэдээллийг баталгаажуулан ХШДА хариуцсан байцаагчаар хянуулж, гүйлгээ хийлгэх баримтыг жагсаалт үйлдэн сангийн нягтлан бодогчид хүлээлгэн өгч ажиллах	Тогтмол	Тогтмол	Аж ахуйн нэгж байгууллагуудаас цахимаар илгээсэн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн анхан шатны баримт /Б-НД-2, Б-НД-2.1/-ын бүрдлийг шалгаж тулган хүлээн авч нягтлан бодогч нар болон даатгуулагчдад зөвлөгөө өгч ажиллалаа. 2024 онд 3529 орчим даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хүсэлтийг хүлээн авч алдаатай илгээсэн болон данс буруу, системийн алдаа, гацалгаас шалтгаалсан 779 хүсэлтийг цуцалж, засварлан 2750 даатгуулагчийн хүсэлтийг шийдвэрлэв.	2024.01.01 2024.12.31	100%
1.1.7	Бүртгэлийн маягтыг батлагдсан зааврын дагуу хөтөлж ажиллах	Албан журмын даатгуулагчийн эмнэлгийн хуудас Б-НД-2 тайлангийн бодолт, тооцооллыг програмд бүртгэн баталгаажуулах, цахим хүсэлт дээрх	Тайлангийн жилд хүсэлт гаргасан ажил олгогч, даатгуулагч нэг бүрийн цахим хүсэлтийг	Тайлангийн жилд хүсэлт гаргасан ажил олгогч, даатгуулагч нэг бүрийн цахим хүсэлтийг	Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн №438 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам”, №439 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс	2024.01.01 2024.12.31	100%

	байгууллагын нэр, банк, дансны дугаар, мөнгөн дүн, хөдөлмөрийн чадвар түр алдсан хоног зэрэг мэдээллийг шалгаж нягтлах	шалгаж хэвшүүлэх	шалгаж хэвшүүлэх	шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам"-ын дагуу тайлангийн жилд нийт 2374 албан журмын даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн баримт бичиг болох эмнэлгийн хуудас /Б-НД-2/-ны тайлангийн бодолт, тооцооллыг програмд бүртгэн баталгаажуулах, цахим хүсэлт дээрх байгууллагын нэр, банк, дансны дугаар, мөнгөн дүн, хөдөлмөрийн чадвар түр алдсан хоног, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хоног зэрэг мэдээллийг шалгаж нягтлан ажиглалаа. Мөн цахимаар хүсэлт илгээсэн 196 сайн дурын даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт илгээсэн 1626 даатгуулагч иргэний хүсэлтийг хүлээн авч алдаатай илгээсэн болон данс буруу, системийн алдаа, гацалтаас шалтгаалсан 294 хүсэлтийг цуцалж, засварлан 1332 даатгуулагчийн хүсэлтийг шийдвэрлэн долоо хоног бүрийн Даваа, Баасан гаригт сангийн нягтлан бодогчид батлагдсан заавар журмын дагуу жагсаалт үйлдэн гүйлгээ хийхэд бэлтгэн хүлээлгэн өгч ажиглалаа.		
ХОЁР: "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД						
2.1.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, бусад мэдээг тухай бүр гаргаж удирдлагад танилцуулж байх - Сарын мэдээ, - Улирлын тайлан,	Тайлан мэдээг хугацаанд нь хийж гүйцэтгэх	-Сарын мэдээ 12, -Улирлын тайлан 4,	-Сарын мэдээ 12, -Улирлын тайлан 4,	Тайлант хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, бусад мэдээг тухай бүр гаргаж удирдлагад танилцуулж ажиглалаа. Үүнд: - Сарын мэдээ 12 удаа,	2024.01.01 2024.12.31 100%

	- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		-Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 2 удаа	-Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 2 удаа	- Тэтгэмжийн улирлын тайлан 4 удаа, - Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2 удаа		
2.2	Иргэд даатгуулагчаас ирүүлсэн өргөдөл хүсэлтийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэнэ	Хүсэлт гаргасан иргэдийн тоогоор	Хүсэлт гаргасан иргэдийн тоогоор	Иргэд даатгуулагч, аж ахуйн нэгж байгууллагуудаас биеэр болон утсаар, цахимаар ирүүлсэн хүсэлтүүдийг тухай бүрд нь шуурхай тодруулан шийдвэрлэж ажилласан ба тэтгэмжтэй холбоотой цаасаар ирсэн 1 өргөдөл, Засгийн газрын 11-11 төвд 8 иргэний гомдол ирснийг тухай бүрд нь шуурхай шийдвэрлэж гомдол гаргасан иргэнд болон холбогдох албан тушаалтанд хариу мэдэгдэн ажиллалаа.	2024.01.01 2024.12.31	100%
2.3	Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллах	Стандартад нийцсэн байна	14-15 боть	14-15 боть	Хэлтсийн даргын тушаалаар томилогдсон "Баримт бичиг нягтлан шалгах комисс" /ББНШК/-ын хурлаар батлагдсан "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажилладаг ба албан тушаалын тодорхойлолтод заагдсан архивт хүлээлгэн өгөх ажиглүйдлийн тэтгэмжийн 2023 оны 15 боть баримтыг хадгаламжийн нэгж болгон хуулийн хугацаанд нь архивын ажилтан М.Нарантуяад хүлээлгэн өгсөн.	2024.01.01 2024.12.31	100%
2.4	Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүрэг хүлээх	Хуульд заасан мэдээллийг бусдад задруулахгүй ажиллана	Өдөр тутамдаа мөрдөж ажиллах	Өдөр тутамдаа мөрдөж ажиллах	Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүргийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллав.	2024.01.01 2024.12.31	100%
2.5	"Нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/-ны үйлчлүүлэгчтэй харилцах журам"-ыг мөрдлөг болгон ажиллах	Өдөр тутмын ажилдаа мөрдөж ажиллана	Тогтмол	Тогтмол	"Нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/-ны үйлчлүүлэгчтэй харилцах журам"-ыг тогтмол мөрдлөг болгон ажиллаж даатгуулагч иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан	2024.01.01 2024.12.31	100%

					нэг бүртэй зөлдэг, найрсат харилцахыг эрхэмлэн ажиллалаа.			
2.6	Үйлчлүүлэгчидтэй нээлттэй утас 70585955 "Call pro" үйлчилгээ	Өдөр ажигладаа ажиглана	тутмын мөрдөж	Тогтмол	Тогтмол	Нийгмийн даатгалын ерөнхий газраас иргэд даатгуулагчидтай харилцах нээлттэй утас 70585955 утсыг "Call pro" үйлчилгээнд холбосонтой холбоотой тэтгэмжийн талаар мэдээлэл авахаар тус утсанд холбогдсон иргэд даатгуулагчдын дуудлага бүрийг харилцлагатай авч хүссэн мэдээллийг өгч ажилласан ба алдсан дуудлагыг эргэж залгаж тодруулан мэдээллийг түргэн шуурхай өгч шийдвэрлэж ажиллалаа.	2024.01.01 2024.12.31	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.1.9	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил	Тогтмол	Тогтмол	Тогтмол	Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан "Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж авлага барагдуулах аян"-ы удирдамжийн дагуу 1-р багт хуваарилагдан сайн дурын даатгалын байцаагч М.Энхцэцэг, бичиг хэргийн ажилтан Б.Отгонцэцэг, тэтгэмжийн байцаагч Б.Гантуяа нартай хамтран 65-н ААН-ийн 353,132,105.23 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулахаар ажиглалаа. 35-н ААН-д улсын байцаагчийн "Албан шаардлага"-ыг биеэр болон цахимаар хүргүүлэн тус албан шаардлагад заасан хугацаанд өр барагдуулаагүй 22 ААН-ийн арилжааны банкн дахь дансыг хаасны үр дүнд 256,525,731.04 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулан ажигласан.	2024.01.01 2024.12.31	100%

1.1.1 0	Нийгмийн даатгалд даатгуулагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх	Тогтмол	Тогтмол	Тогтмол	Аймгийн хэмжээнд 2024 оны 1-6-р сард ажиглүүдлийн тэтгэмжийг хариуцан ажиллаж байх хугацаандаа 177 даатгуулагч ажиглүүдлийн тэтгэмж авах хүсэлт гаргасан ба ажлаас чөлөөлөгдсөн хүн бүрд сайн дурын даатгалд үргэлжлүүлэн даатгуулахыг зөвлөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт тасарсан тохиолдолд учирч болох эрсдэл, хор хохирлын талаар болон тасралтгүй нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлыг тайлбарлан ойлгуулж ажигласнаар 70 орчим ажиглүүдлийн тэтгэмж авач үргэлжлүүлэн сайн дурын даатгалд хамрагдсан ба нийт тайлант хугацаанд ажиглүүдлийн тэтгэмжид хамрагдсан иргэдийн 39,5 хувь нь сайн дурын даатгалд хамрагдаад байна.	2024.01.01 2024.12.31	100%
1.1.1 1	Хүний нөөцийн чиглэлээр хийж гүйцэтгэх ажил	Тухай бүрд	Тухай бүрд	Тухай бүрд	-Бичиг хэрэг, хүний нөөц, дотоод асуудал хариуцсан ажилтны сул орон тоо нөхөгдөхгүй байгаатай холбоотой тэтгэмжийн байцаагчийн ажилтай хавсран хүний нөөцийн ажилтны албан үүргийг гүйцэтгэв. Үүнд: Тус хэлтэст гарсан сул орон тооны мэдээллийг тухай бүрд нь төрийн албаны зөвлөлд албажуулан хүргүүлж тусгай шалгалтын захиалгыг өгч, нөхөгдсөн албан тушаалын мэдээллийг хүний нөөцийн ХНУМТ, GREEN ERP програмуудад бүртгэж, сар бүр орон тооны гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 05-ны дотор НДЕГ-ын тамгын газрын хүний нөөц хариуцсан мэргэжилтнүүдэд мэдээлж ажиллалаа. -Тайлант хугацаанд сургалт сурталчилгаа, мэдээллийн технологи	2024.01.01 2024.12.31	100%

					хариуцсан мэргэжилтэн, үйлчилгээний тасгийн дарга, хяналт шалгалтын байцаагч, тэтгэврийн байцаагч, Баян-Уул, Хөлөнбуйр сумдын нийгмийн даатгалын байцаагчийн сул орон тооны мэдээллийг төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоол "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай"-ын дагуу тухай бүрд нь зарлуулж ажилласан ба сургалт сурталчилгаа, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн, хяналт шалгалтын байцаагч, Хөлөнбуйр, Баян-Уул сумдын нийгмийн даатгалын байцаагчийн сул орон тоо нөхөгдсөн байна. -Тус хэлтэст олон жил үр бүтээлтэй ажилласан байцаагч ажилтнуудыг хамт олны хурлын шийдвэрээр шагналд тодорхойлоход шагналд нэр дэвшүүлсэн ажилтнуудын анкет, тодорхойлолт, өмнө авсан шагналын гэрчилгээний хуулбар зэрэг холбогдох материалуудыг журмын дагуу боловсруулан илгээх ажлыг бичиг хэргийн ажилтан Б.Отгонцэцэгтэй хамтран хийж гүйцэтгэлээ. 2024 онд Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны "Тэргүүний ажилтан" цол тэмдгээр хяналт шалгалтын байцаагч Д.Ганбүгдэд, орлого, шимтгэлийн байцаагч Т.Ариунаа нарын нийт 2 ажилтан тус тус шагнагдсан байна.		
1.1.1 2	Нийгмийн даатгалын сангийн 2025-2027 оны төсвийн төсөөлөл боловсруулах ажилд оролцох	Тухай бүрд	Тухай бүрд	Тухай бүрд	Нийгмийн даатгалын газраас жил бүр хийдэг нийгмийн даатгалын сангийн 2025-2027 оны төсвийн төсөөлөл боловсруулахад шаардлагатай тэтгэмжийн даатгалын сангийн 2023		

				оны гүйцэтгэл, 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгаа, 2025-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулахад оролцон удирдлага болон холбогдох мэргэжилтэн болон ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр ханган ажиллалаа.		
--	--	--	--	---	--	--

Гурав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	5	6			7
	1	2	3	4						
3.1	Салбарын хэмжээнд болон аймаг, орон нутгаас, хэлтсээс зохион байгуулагдсан сургалтуудад хамрагдах	Сургалтад хамрагдах	Хууль эрх зүй, цаг үеийн холбогдолтой мэдлэг, мэдээлэлтэй болсон байна	Хууль эрх зүй, цаг үеийн холбогдолтой мэдлэг, мэдээлэлтэй болсон байна	- Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн батлагдсан “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн танилцуулга сургалтыг НДЕГ-аас цахимаар зохион байгуулахад оролцсон. - Sicos.ndaafgal.mn шинэ системийн ашиглалттай холбоотой 12 удаагийн Zoom сургалтанд холбогдох байцаагч, ажилтнуудтай хамтран оролцсон. - НДЕГ-аас системийн хэмжээнд албан ёсоор зохион байгуулж буй “Монгол бичиг”-ийн 8 удаагийн сургалтад хамрагдаад байна.		2024.01.01 2024.12.31	100%		
3.2	Системийн хэмжээнд шинээр нэвтэрсэн программ хангамж, хууль, журам, дүрмийг судлах	Шинээр нэвтэрсэн программ хангамж, хууль, журам, дүрмийг судлах	Хууль эрх зүй, цаг үеийн холбогдолтой мэдлэг, мэдээлэлтэй болсон байна	Хууль эрх зүй, цаг үеийн холбогдолтой мэдлэг, мэдээлэлтэй болсон байна	Шинэ системтэй холбоотой албан ёсны сургалт, цахим уулзалтуудад оролцохоос гадна системийн ажиллагаанд гарч байгаа гацалт, түүнээс үүдэлтэй алдааг залруулах зэрэг хүндрэлтэй асуудлуудыг цаг тухай бүрд нь судлан холбогдох мэргэжилтэн, албан хаагчидтай хамтран ажиллаж иргэд даатгуулагчдад чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч ажиллалаа.		2024.01.01 2024.12.31	100%		

					Мөн шинээр мөрдөгдөж буй "Нийгмийн даатгалын багц хууль", түүнийг дагалдан гарсан журам, дүрмийг судлан хэрэгжүүлэх ажлыг тасралтгүй хийж гүйцэтгэн ажиллалаа.		
3.3	НДЕГ, НДГ-аар, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдах	Дээд газраас зохион байгуулсан сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	Сургалтад хамрагдсан байх	-Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг 7:4:10 Монгол Улсын Их сургуулийн зөвлөх багш, доктор, профессор Л.Оюуны явуулсан "Байгууллага хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага" сэдэвт сургалт, Ерөнхийлөгчийн дэргэдэх "Хэлний бодлогын үндэсний зөвлөл"-ийн Ажлын албаны дарга, доктор Н.Нарангэрэл, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа нарын "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-II"-г зохион байгуулахтай холбоотой асуудлаар хийсэн сургалт мэдээлэл, Монгол Улсын Их сургуулийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн ахлах багш доктор (Ph.D) Г.Мягмарын "Төрийн албаны үнэт зүйл, үе хоорондын ялгаатай байдал" сэдвээр зохион байгуулсан сургалтуудад тогтмол идэвхтэй хамрагдан сургалтаас олж авсан мэдлэгээ өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажиллаж ирлээ.	2024.01.01 2024.12.31	100%
3.4	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд ашиглагдах программ хангамж, тоног төхөөрөмж дээр ажиллах чадварыг эзэмших	Ашиглагдаж буй программыг бүрэн ашиглаж чаддаг байх	Ашиглагдаж буй программыг бүрэн ашиглаж чаддаг болсон байна	Ашиглагдаж буй программыг бүрэн ашиглаж чаддаг болсон байна	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд ашиглагдах программ хангамж, тоног төхөөрөмж дээр ажиллах чадварыг эзэмшихээс гадна шаардлагатай мэдээллүүдийг бүртгэх явцад хүндрэлтэй байгаа болон ажлын явцад илэрч байгаа зарим алдааг бүртгэн холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлж, засаж	2024.01.01 2024.12.31	100%

					залруулах гэх мэт ажлуудыг хийж ажилланаа.		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРТАСАН:

ТЭТГЭМЖИЙН БАЙЦААГЧ

Ч.Бямбахишиг

Ч.БЯМБАХИШИГ

2024.12.06.